

ХИЛИЙН ЧАНАДАД ОРШИН СУУГЧ БНСУ ИРГЭН (F-4) АНГИЛЛЫН ВИЗТЭЙ ИРГЭНИЙ ЭХНЭР/НӨХӨР, НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮҮХЭД (F- 1- 9)

(Бүртгэлтэй хаягийн харьяа Элчин сайдын яаманд мэдүүлэх)

ОЛГОХ ХҮРЭЭ:

F-1-9: Хилийн чанадад оршин суугч БНСУ иргэн (F-4) ангиллын визтэй иргэний эхнэр/нөхөр, насанд хүрээгүй хүүхэд

Хилийн чанадад оршин суугч БНСУ иргэн (F-4) ангиллын визтэй иргэний эхнэр/нөхөр, насанд хүрээгүй хүүхдийн визээр Монгол Улсаас БНСУ-д зорчихыг хүсч буй иргэн Солонгосын Виз Мэдүүлгийн Төвөөр дамжуулан виз мэдүүлнэ. Та нэг удаагийн, нэг жил хүртлэх виз мэдүүлэх боломжтой. Виз шалгагдах явцад БНСУ-ын ЭСЯ-аас нэмэлт бичиг баримтыг шаардах боломжтой.

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт (Сүүлийн 6 сарын дотор авахуулсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг)
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь (Виз мэдүүлж буй өдрөөс хойш хамгийн багадаа 6 сарын хүчинтэй байх)
3. Цагдаагийн газрын тодорхойлолт (18–аас дээш, 60-аас доош насны анх удаа зорчиж буй иргэнд хамаарна)
4. Гэрлэлтийн лавлагаа
 - 18 наснаас доош бол төрсний бүртгэлийн лавлагаа өгөх (эцэг эхийн төрсөн он сар өдөр тэмдэглээгүй бол иргэний үнэмлэхийн хуулбар хавсаргах)
5. Сүрьеэгийн шинжилгээний бичиг (БНСУ-ын ЭСЯ-аас заасан эмнэлэг)
6. Хилийн чанадад оршин суугч (F-4) ангиллын визтэй иргэний хаягийн бүртгэл хийлгэсэн бичиг баримт эсхүл визтэй хэсгийн хуулбар
7. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг баримт (Гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа, төрсний бүртгэлийн лавлагаа зэрэг)
8. Оршин суух газар болон амьжиргааны чадварыг нотлох бичиг баримт
 - Оршин суух газрын нотлох бичиг баримт (Түрээсийн гэрээ, Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар гэх мэт)
 - Орлого нотлох бичиг баримт (Ажлын газрын тодорхойлолт, Цалингийн данс эсхүл харилцах дансны гүйлгээний хуулга гэх мэт)